



ДУНДГОВЬ АЙМАГ
БАЯНЖАРГАЛАН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 02 сарын 16 өдөр

Дугаар А/11

Аргатай

Төлбөр тооцоо гүйцэтгэх
эрх олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4, 14.5, Засгийн газрын 2015 оны 24 дүгээр тогтоолын хавсралтын 7 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.100080555405 тоот "Байгаль хамгаалах сан", 100080555407 тоот "Мал хамгаалах сан"-ийн бүртгэлийн дансуудад хяналт тавьж, зарлагын гүйлгээний төлбөр тооцоог гүйцэтгэх баримтанд 1 дүгээр гарын үсэг зурах эрхийг Засаг даргын Тамгын газрын дарга (Р.Отгонбаатар), 2 дугаар гарын үсэг зурах эрхийг Засаг даргын Тамгын газрын ерөнхий нягтлан бодогч (А.Цогзолмаа) нарт түр хугацаагаар олгосугай.

2. Төрийн сангийн үйл ажиллагааны журмыг мөрдөж ажиллахыг Төсвийн шууд захирагч (Р.Отгонбаатар), нягтлан бодогч (А.Цогзолмаа) нарт үүрэг болгосугай.

ДАРГА
ЦЭВЭЛМАА

482301038